МУИС - Бодлогын Судалгааны Лаборатори

“ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ШАЛГАЛТАД БЭЛТГЭХ”СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Боловсруулсан: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн, Хувийн эрх зүйн тэнхимийн доктор Ph.d, Профессор, /С.Должин/ доктор Ph.d, Дэд профессор, /Б. Тэмүүлэн/

Огноо: 2026.10.09

АГУУЛГА

I ХЭСЭГ. СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА *3*

1. Сургагч багшид тавигдах шаардлага: 3
2. Сургалтад хамрагдаж болох хуульчдын хүрээ 3
3. Сургалт явуулах арга зүй 3
4. Сургалтын хугацаа 3
5. Цагийн багтаамж, олгогдох багц цаг 3
6. Сургалтын хэлбэр: 3
7. Сургалтын төлбөр: 3
8. Сургалт явуулах байгууллага 3
9. Сургалт явагдах хугацаа, давтамж 3

II ХЭСЭГ. СУРГАЛТЫН ТОВЧ АГУУЛГА *3*

1. Сургалтын нэр, төрөл, мэргэшүүлэх чиглэл 3
3. Сургалтын зорилт, зорилго: 4
4. Сургалтын ач холбогдол 6
5. Сургалтын агуулга 8

III ХЭСЭГ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ *6*

1. Үнэлгээний зорилго 6
2. Үнэлгээний шалгуур 7
3. Үнэлэх арга, хэлбэр 7

I ХЭСЭГ. СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

1. **Сургагч багшид тавигдах шаардлага:**

   Хуульчийн үргэлжилсэн сургалтыг заах багшид тавигдах шаардлага нь МУИС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн мэргэшсэн, дэд профессорын цолны шалгуурыг хангаж эрдмийн цолоо авсан байна.

2. **Сургалтад хамрагдаж болох хуульчдын хүрээ:**
   Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүйн онол- практик сургалтын сэдвийн чиглэлээр хуульчийн мэргэжлийн Иргэний эрх зүйн шалгалтад бэлдэж буй оролцогчид, Иргэний эрх зүйн чиглэлээр туслалцаа үзүүлэх мэдлэг, чадвараа дээшлүүлэх сонирхолтой иргэд, мэргэжилтнүүд, Онол-практикийн мэдлэг, туршлагаа гүнзгийрүүлэх хууль зүйн туслалцааны төвийн хуульч, өмгөөлөгчид бусад хуульчид сургалтанд хамрагдах боломжтой**.**

3. **Сургалт явуулах арга зүй:**

   Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүйн онол- практик сэдвийн сургалтыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалт түүний практик хэрэгжилтийг онол- практикийн түвштинд хослуулан судалж улмаар Иргэний эрх зүйн гэрээний маргааныг эрх зүйн фактаар ялган хэм хэмжээний хэрэглээ болон Гэр бүлийн маргаан, гэрлэлт цуцлалтаас үүссэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн шийдлийг эзэмшүүлэх лекц, хэлэлцүүлэг, кейс, тохиолдолд дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан явуулна.

   Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь эрх зүйн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, мөн ямар асуудал оршиж байгаа тухай ойлгох хамгийн чухал арга учраас шүүхийн шийдвэрийг шинжлэн судлах, дүгнэлт хийнэ.

4. **Сургалтын хугацаа:** 14 хоног
5. **Цагийн багтаамж :** 1 өдөр 4 цаг
6. **Сургалтын хэлбэр:** тэнхим болон цахим сургалт
7. **Сургалтын төлбөрийн хэмжээ:** 450. 000 төгрөг
8. **Сургалт явуулах байгууллага:**Монгол Улсын их сургуулийн Бодлогын Судалгааны Лаборатори
9. **Сургалт явагдах хугацаа, давтамж:** Нэг удаагийн 14 хоногийн үргэлжилсэн сургалт

II ХЭСЭГ. СУРГАЛТЫН ТОВЧ АГУУЛГА

1. **Сургалтын нэр, төрөл, мэргэшүүлэх чиглэл:**

   Хувийн эрх зүйн дэд салбар эрх зүй болох Хувийн эрх зүй, Гэр бүлийн эрх зүйн чиглэлийн хүрээнд онол- практик хосолсон сургалтын чиглэлээр мэргэшүүлнэ.
2. **Сургалтын товч агуулга:**

Хувийн эрх зүйн салбарын бие даасан салбар эрх зүй болох Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүйн судалгааны объект болох гэрээ, түүний төрөл, гэрээ хүчин төгөлдөр эсэх, хүчин төгөлдөр бусд тооцуулах, гэрээний үүргийн хэрэгжилт, гэрээг цуцлах мөн шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтаас үүсэх хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчмыг баримтлах үзэл баримтлал түүнийг тайлбарлах онол, арга зүйг системтэй заана. Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны талаар системтэй мэддэг эзэмших, гэр бүлийн эд хөрөнгийг ангилан, хамаарагдах эд хөрөнгийг зөв тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах, холбогдох хуулийн заалтыг сонгон хэрэглэх, хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийх, гэрээ боловсруулах чадвартай болж цаашид энэ асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийг ангилж дүн шинжилгээг хийх хэм хэмжээний хэрэглээний ур чадаврыг эзэмшүүлнэ.

3. Сургалтын зорилт, зорилго:

Монгол улсад Иргэний эрх зүй болон Гэр бүлийн эрх зүйн арга хэрэгслийн талаар тодорхой мэдлэгтэй болж, тодорхой тохиолдол тус бүрт ямар арга хэрэглэх нь хүүхдийн эрх ашигт нийцэх талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, тухай аргыг хууль зүйн дагуу хэрэгжүүлэх чадвартай болж, цаашид энэ асуудалд эрх зүйн талаас нь хандах хандлага төлөвшүүлэхийн тулд онол, практикийн цэгцтэй мэддэгийн үндсэн дээр хууль зүйн дүгнэлт хийх, хуулийг сонгон хэрэглэх, түүний үр дагаврыг тайлбарлах чадварыг эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.Үүнд:

1. Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүйн онолын мэдлэгийг мэргэшүүлэх түвшинд олгоно.
2. Шүүхийн практикийн үндсэн дээр онол-практикийн хууль зүйн дүгнэлт хийх, хуулийг сонгон хэрэглэх, түүний үр дагаврыг тайлбарлах чадварыг эзэмшүүлж улмаар хууль зүйн туслалцаа үзүүлэх дадал, чадвар эзэмшүүлэхэд оршино.

4. Сургалтын нарийвчилсан төлөвлөгөө

Дугаар	Огноо	Сургалтын цаг	Сургалтын агуулга	Сургалт орох багш
1	2026.10.12	4 цагийн сургалт	1.Иргэний эрх зүйн бодлого бодох аргачлал: -Шаардах эрхийг олох аргачлал -Шаардах эрх шалгах дараалал - Шаардах эрхийг шалгах алхам 2. Шаардах эрхийн тухай ойлголт, субъектив эрхийн тухай ойлголт, хэм хэмжээний урьдчилсан нөхцөл, ач холбогдол	Б.Тэмүүлэн

			3. Гэрээ байгуулахтай холбоотой, хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр болох, төлөөллийн сэдвээр бодлого бодох	
2	2026.10.13	4 цагийн сургалт	Хэлцэл хүчин төгөлдөр бус байх, хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцохтой холбоотой бодлого бодох Холимог гэрээг, түүний хууль тогтоомжийн хэрэглээг анхаарах бодлого	С.Должин
3	2026.10.14	4 цагийн сургалт	Үүргийн эрх зүйн шаардах эрхүүдийг шалгах бодлого бодох, үүнд: - Үүргийг зохих ёсоор биелүүлэх - Үүрэг зөрчсөн үед учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардах эрх - Гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахтай холбоотой шаардах эрхийг шалгах	Б.Тэмүүлэн
4.	2026.10.15	4 цагийн сургалт	Үүргийн тусгай төрлүүдтэй холбоотой бодлого бодох: - Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээ - Бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээ - Ажил гүйцэгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ	С.Должин
5.	2026.10.16	4 цагийн сургалт	Хуульд зааснаас үүсэр үүргийн харилцаатай холбоотой бодлого бодох: - Үндэслэлгүйгээр хөрөнгөжих - Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх - Гэм хорын	Б.Тэмүүлэн

6.	2026.10.19	4 цагийн сургалт	Өв залгамжлалын эрх, Эдийн баялгийн эрхтэй холбоотой бодлого бодох аргачлалыг эзэмшүүлэх	Б.Тэмүүлэн
7.	2026.10.20	4 цагийн сургалт	Гэр бүлийн эрх зүйн бодлого бодох аргачлал эзэмшүүлэх	С.Должин
8.	2026.10.21	4 цагийн сургалт	Хуульчдын сонгон шалгаруулалтын сорилын асуудлыг шинжлэн судлах	Б.Тэмүүлэн
9.	2026.10.22	4 цагийн сургалт	Хуульчдын сонгон шалгаруулалтын сорилын асуудлыг шинжлэн судлах	С.Должин
10.	2026.10.23	Хуульчдын сонгон шалгаруулалтын сорилын асуудлыг шинжлэн судлах	Сургалтын сэдвээр оролцогчдоос асуух асуултанд хариулах, нэмэлт үндэслэл, аргачлалыг хэлэлцэх	С.Должин Б.Тэмүүлэн

4. Сургалтын ач холбогдол:

Онолын мэдлэг дээрээ тулгуурлан шүүхийн практикт холбогдох хууль тогтоомжийн хэм хэмжээний хэрэглээг судалж түүний ач холбогдлыг тайлбарлан таниулахэхад энэхүү сургалтын гол ач холбогдол оршино.

Энэхүү онол-практикийн хослуулсан сургалт нь дараах ахисан түвшний мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ. Үүнд:

1. Хуульчийн мэргэжлийн Иргэний эрх зүйн сорилгын онолын мэдлэг эзэмших, олж авсан мэдлэг дээрээ үндэслэн энэ харилцаатай хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн заалтыг тайлбарлах чадвар эзэмшинэ.
2. Иргэний эрх зүйн бодлого, Гэр бүлийн маргаантай холбоотой бодлого бодох аргачлал,, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах, холбогдох хуулийн заалтыг сонгон хэрэглэх, хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийх, гэрээ боловсруулах чадвартай болно.

III ХЭСЭГ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

1. Үнэлгээний зорилго:

Сургалтаар олж авсан онол-практикийн мэдлэг, чадварыг бататгах, багц тооцоход энэхүү үнэлгээний зорилго чиглэнэ.

2. Үнэлгээний шалгуур:

Онолын мэдлэгийн үнэлгээний шалгуур

Суралцагчийн онолын мэдлэгийг сургалтын дэд сэдвүүдийн агуулгатай уялдуулан боловсруулсан эрх зүйн сорил, асуулт-хариулт болон богино хэмжээний тестийн үр дүнд үндэслэн үнэлнэ. Үнэлгээнд хууль тогтоомжийн агуулгыг ойлгосон байдал, эрх зүйн ойлголт, нэр томьёог зөв хэрэглэсэн байдал, онолын мэдлэгийг эзэмшсэн түвшинг харгалзан дүгнэнэ.

Практик ур чадварын үнэлгээний шалгуур

Суралцагчийн практик ур чадварыг шүүхийн бодит хэрэг, маргааныг кейсээр шийдвэрлэх явцад холбогдох хууль тогтоомжийн хэм хэмжээг зөв сонгон хэрэглэж буй байдал, эрх зүйн үндэслэлээ хууль болон шүүхийн практикт тулгуурлан тайлбарлаж, нотлон үндэслэх чадвар, эрх зүйн дүгнэлт хийж, хуулийн зүйл, заалтыг оновчтой зүйлчилж хэрэглэх чадвар, мөн сургалтаар эзэмшсэн онолын мэдлэгийг практикт үр дүнтэй ашиглаж буй байдлыг гол шалгуур болгон үнэлж дүгнэнэ.

3. Үнэлэх арга, хэлбэр :

Онолын мэдлэгийн үнэлэхэд суралцагч тус бүрээр сургалтын дэд сэдвийн агуулгатай холбоотой эрх зүйн сорилгын оноог харгалзан дүгнэнэ.

Практик мэдлэг, ур чадварыг үнэлэхэд дэд сэдэв бүрийн хүрээнд суралцагчдыг баг болгон хувааж багийн нийт гишүүдийн нэгдсэн шүүмж, хэлэлцүүлгээр дэвшүүлсэн санааг харгалзан багийн үнэлгээгээр тооцно.

Дараах байдлаар онолын мэдлэг үнэлэх хувь (40%), практик ур чадварыг үнэлэх хувь (60%)-иар үнэлнэ.

Үнэлгээний чиглэл	Үнэлгээний шалгуур	Оноо
1. Онолын мэдлэг (40 оноо)	Эрх зүйн үндсэн ойлголт, нэр томьёог зөв тайлбарласан байдал	10
	Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг зөв мэдэж хэрэглэсэн байдал	15
	Онолын агуулгыг ойлгож, сорил, асуулт-хариултад зөв хариулсан байдал	15
Дүн		**40**
2. Практик ур чадвар (60 оноо)	Хэрэг маргаанд хамаарах эрх зүйн асуудлыг зөв тодорхойлсон байдал	10
	Холбогдох хууль тогтоомж, хуулийн зүйл, заалтыг оновчтой сонгон хэрэглэсэн байдал	15
	Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд эрх зүйн дүн шинжилгээ хийсэн байдал	15
	Эрх зүйн үндэслэлээ логик дараалалтай тайлбарлаж, нотолсон байдал	10

Үнэлгээний чиглэл	Үнэлгээний шалгуур	Оноо
	Хууль зүйн дүгнэлт гаргаж, онолын мэдлэгийг практикт зөв ашигласан байдал	10
Дүн		**60**
НИЙТ		**100**

Үнэлгээний түвшин

- 90–100 оноо – Маш сайн
- 80–89 оноо – Сайн
- 70–79 оноо – Хангалттай
- 60–69 оноо – Дунд
- 60-аас доош – Хангалтгүй